



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДУЛААНЫ ТЕНХИК, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН -ИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/16/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн :
Баян ташаагийн эх Аудит ХХК
Захирал: Т.Хоролсүрэн
Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
4.1 Байгууллагын үйл ажилагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэнжилт.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
8. Аудитын илрүүлэлт.....	16
8.1 Залруулсан алдаа.....	17
8.2 Төлбөрийн акт.....	17
8.3 Албан шаардлага.....	17
8.4 Зөвлөмж.....	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УТҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ЭМНДШ	Эрүүл мэнд нийгмийн даатгал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Утас:26-04-37, Факс:51-26-42-30

E-mail: info@audit.gov.mn

ДУЛААНЫ ТЕХНИК,ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УТҮГ -ЫН
ЗАХИРАЛ Х.ЭНХЖАРГАЛ ТАНАА

2022.03.15 № 07/559
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ нь 2015 оны Засгийн газрын 27 тоот тогтоолоор төсвийн бус хөрөнгөөр ажиллахаар тусгагдсан “Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” гэсэн статустай үйл ажиллагаа явуулдаг ШУТИС-ийн харьяа, ТУЗ байхгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 30.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M.

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	121,291,326.41	142,476.44
1.1.6	Бараа материал	72,105,519.62	24,122,420.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	317,002,300.00	317,002,300.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	510,399,146.03	341,267,196.44
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,200,553,960.47	1,085,016,075.17
1.2.2	Биет бус хөрөнгө	53,251,000.00	53,251,000.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,253,804,960.47	1,138,267,075.17
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,764,204,106.50	1,479,534,271.61
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	0.00	26,630,935.59
2.1.1.3	Татварын өр	1,010,653.92	10,763,635.50
2.1.1.4	НДШ-ийн өглөг	4,726,050.37	34,202,314.63
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	1,286,750.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	5,736,704.29	72,883,635.73
2.3.1	Төрийн өмч	319,956,570.00	319,956,570.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	434,682,411.72	434,682,411.72
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,003,828,420.49	652,011,654.16
2.3.20	Эздийн өмчийн дүн	1,758,467,402.21	1,406,650,635.88
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,764,204,106.50	1,479,534,271.61

/төгрөгөөр/

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,079,845,102.00	199,307,640.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	1,079,845,102.00	199,307,640.00
4	Түрээсийн орлого	47,416,180.00	41,850,000.00
5	Хүүгийн орлого	84,477.44	300.00
8	Бусад орлого	39,177,065.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,343,755,467.76	591,419,586.33
11	Санхүүгийн зардал	1,500,000.00	1,500,000.00
12	Бусад зардал	350,300.00	55,120.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,179,162,675.32)	-351,816,766.33
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,179,162,675.32)	-351,816,766.33

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
---	----------	-----	------------------------	-------------------------------------	---------------------------	--------------------	----------

Дулааны, техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	266,705,570.00		434,682,411.72		770,769,579.45	1,472,157,561.17
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					149,966,500.00	149,966,500.00
3	Залруулсан үлдэгдэл	266,705,570.00		434,682,411.72		920,736,079.45	1,622,124,061.17
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	53,251,000.00				199,304,972.26	252,555,972.26
9	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	319,956,570.00		434,682,411.72		1,003,828,420.49	1,758,467,402.21
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-		-351,816,766.33	-351,816,766.33
17	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	319,956,570.00		434,682,411.72		652,011,654.16	1,406,650,635.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,255,832,310.44	241,157,640.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,079,845,102.00	199,307,640.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	175,902,731.00	41,850,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,267,112,074.34	359,366,789.98
1.2.1	Ажиллагчдад төлсөн	119,778,740.00	75,266,375.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,585,271.97	00.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,495,885.57	70,282,180.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	15,093,795.77	417,707.97
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,461,200.00	1,411,950.01
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,426,906.90	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,109,270,274.13	211,988,577.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,364,241.34)	-118,209,149.98
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	84,477.44	300.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	84,477.44	300.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	2,940,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	84,477.44	-2,939,700.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(11,279,763.90)	-121,148,849.97
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	132,571,090.31	121,291,326.41
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	121,291,326.41	142,476.44

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналтын ажилтан байхгүй, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд зарим ажилтнуудтай байгуулсан гэрээ болон ашиглагдахгүй бараа материалын нөөцийг холбогдох хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэх, батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй зардлыг санхүүжүүлэхгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 3 дугаар сарын 10-ны хооронд Баян ташаагийн эх Аудит ХХК-ийн захирал Т.Хоролсүрэн, аудитор Б.Хандсүрэн аудиторов туслах Д.Балжирдорж нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Ч.Чимгээ хэрэгжүүлсэн.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 012 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ -ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн

нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 2,345.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 23.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ -ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг хот суурин, үйлдвэрийн экологийн карт зохиох, орон сууц, нийтийн аж ахуй, үйлдвэрийн хатуу хаягдлыг боловсруулан ашиглах технологи, үйлдвэрийн экологийн эдийн засгийн үнэлгээ, мөн энэ чиглэлээр арга зүй боловсруулах гэж тодорхойлжээ.

Тус байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай, өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ нь 2015 оны Засгийн газрын 27 тоот тогтоолоор төсвийн бус хөрөнгөөр ажиллахаар тусгагдсан “Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” гэсэн статустай үйл ажиллагаа явуулдаг ШУТИС-ийн харьяа, ТУЗ байхгүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3 “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмч зэрэг дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	121,291.3	142.4	-121,148.9
Урьдчилж гарсан зардал тооцоо	317,002.3	317,002.3	-
Бараа материал	72,105.5	24,122.4	-47,983.1
Үндсэн хөрөнгө	1,200,553.9	1,085,016.0	-115,537.9
Биет бус хөрөнгө	53,251.0	53,251.0	-
Нийт хөрөнгийн дүн	1,764,204.1	1,479,534.3	-284,669.8
Өр төлбөрийн дүн	5,736.7	72,883.6	67,146.9
Дансны өглөг	0.00	27,917.6	27,917.6
Татварын өр	1,010.6	10,763.6	9,753.0
НДШ-ийн өглөг	4,726.0	34,202.3	29,476.3
Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,736.7	72,883.6	67,146.9
Эздийн өмчийн дүн	1,758,467.4	1,406,650.6	-351,816.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,764,204.1	1,479,534.3	-284,669.8

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 121.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явагдаагүйгээс шалтгаалсан.

Бараа материал дансны үлдэгдэл 47.9 сая төгрөгөөр буурсан нь 115.6 сая төгрөгийн материал худалдан авч, захиралын 2021 оны А/02 дугаар тушаалаар 48.3 сая төгрөгийн хангамжийн материал акталж, 115.2 сая төгрөгийг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 115.5 сая төгрөгөөр буурсан нь худалдан авсан хөрөнгө 2.9 сая, ТӨБЗГ-ын 2021 оны 623 дугаар тогтоолын дагуу 7.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, элэгдлийн зардал 110.6 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 67.1 сая төгрөгөөр өссөн нь цалингийн өглөг 26.6 сая, татварын өр 9.8 сая, НДШ-ийн өглөг 29.5 сая, бусад өглөг 1.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ШУТИС-ын захирлын тушаалаар Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын 2021 оны санхүүжилт, төсвийн хуваарийг баталсан байна.

БШУЯ-наас хөтөлбөр арга хэмжээний санхүүжилтээр 199.3 сая төгрөг, түрээсийн орлого 41.5 сая төгрөг тус тус орж ирсэн байна.

Гүйцэтгэлээр 241.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 592.9 сая төгрөгийн зардал гарган, 351.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дулааны тенхик, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ нь тайлант онд нийт 642.2 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 642.2 сая төгрөгийн 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 195.7 сая төгрөгийн зөрчилд 4.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 31.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 160.3 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	3	4.2	3	4.2			100
Албан шаардлага	1	31.2	1	31.2			15.9
Зөвлөмж	4	160.3	4	160.3			100
Нийт дүн	8	195.7	8	195.7			100

Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалттай байна

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд УТҮГ гэсэн бүртгэлтэй тул санхүүгийн тайлангийн аудитын хугацааг ТШЗ-аар хийх нь зүйтэй гэж үзэж байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 5.8 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн

Залруулагдаагүй 4.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 23,2 мянган төгрөгийн материаллаг түвшинээс 19.2 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт:

1. Базаар ингтернэйшнл ХХК-тай байгуулсан түрээсийн орлогын 3.0 сая төгрөгөөс 1.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, өглөгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 50 дугаар тогтоолор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ын 3.6-д түрээслэгч нь түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 40 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Илрүүлэлт:

2. Бусдаар гэрээгээр гүйцэтгүүлсэн 16 гэрээт ажил үйлчилгээний 46.5 сая төгрөгний хөлснөөс 4.6 сая төгрөгийн ХХОАТ суутаагүй байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар 7.1.6."үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж тэдгээртэй адилтгах бусад орлого; 23 дугаар зүйл 23.1 17 дугаар зүйл ,22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ноогдуулна гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Татварын цахим тайлангийн системийн ХХОАТ-ын үлдэгдэл 12.3 сая төгрөг, санхүүгийн тайлангаар 10.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй санхүүгийн тайланд 1.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6."Харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийхээс гадна төрийн эрх бүхий байгууллага нь энэхүү цахим санд баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг ашиглана";, 20.2.9."аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах"; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах .

Илрүүлэлт:

2. Нийгмийн даатгалын тайлангийн эцсийн үлдэгдэл 31.5 сая төгрөг, санхүүгийн тайлангийн үлдэгдэл 34.2 сая төгрөг, НДШ-н өглөгийг 2.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах";, 20.2.7."аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах,

тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”; заалтуудыг мөрдөж ажиллах.

Өгсөн зөвлөмж :

Нийгмийн даатгалын хэлтэстэй тооцоо нийлж үлдэгдлийг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/																
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
	Дулааны техник, үйлдвэрлэлийн экологин хүрээлэн УТҮГ	АХГ-2022/16/НА-СТА-ТӨА	Базаар ингтернэйшнл ХХК-тай байгуулсан түрээсийн орлогын 3.0 сая төгрөгөөс 1.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, өглөгөөр бүртгээгүй байна.	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 50 дугаар тогтоолор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний түрээслэгч нь түрээсийнтөлбөрийн нийт дүнгийн 40 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ гэсэн заалтыг мөрдөж ажиллах	1	1,200.0			1	1,200.0						
			Бусдаар гэрээгээр гүйцэтгүүлсэн 16 гэрээт ажил үйлчилгээний 46.5 сая төгрөгний хөлснөөс 4.6 сая төгрөгийн ХХОАТ суутаагүй байна.	ХХОАТ-ын тухай хуулийн 7 дугаар 7.1.6."үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж тэдгээртэй адилтгах бусад орлого; 23 дугаар зүйл 23.1 17 дугаар зүйл ,22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ноогдуулна гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй	1	4,649.9			1	4,649.9						

Дулааны, техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			Татварын цахим тайлангийн системийн ХХОАТ-ын үлдэгдэл 12.3 сая төгрөг, санхүүгийн тайлангаар 10.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй санхүүгийн тайланд 1.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6."Харилцагч санхүүгийн байгууллагын баталгаажуулсан цахим санхүүгийн тайланд үндэслэн холбогдох байгууллага татвар, шимтгэл, хураамжийн тооцоо хийхээс гадна төрийн эрх бүхий байгууллага нь энэхүү цахим санд баталгаажсан аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан, тодруулгыг ашиглана", 20.2.9.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; гэсэн заалтыг мөрдөж ажиллах.	1	1,540.8									1	1,540.8
			Нийгмийн даатгалын тайлангийн эцсийн үлдэгдэл 31.5 сая төгрөг, санхүүгийн тайлангийн үлдэгдэл 34.2 сая төгрөг, НДШ-н өглөгийг 2.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5."дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.7.аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах; заалтуудыг мөрдөж ажиллах	1	2,740.7									1	2,740.7
ДҮН					4	10,131.4			2	5,849.9					2	4,821.5
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
			Шилэн дансны цахим системд нийт 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 642.2 сая төгрөгийн 35 мэдээллийг хугацаа хоцроож	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	642,164.5					1	642,164.5				

Дулааны, техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

		шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй.													
	ДҮН			1	642,164.5					1	642,164.5				
	НИЙТ ДҮН			5	652,295.9			2	5,849.9	1	642,164.5			2	4,821.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 392/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/16/НА - СТА - УТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд ажил, гүйлгээний нийт 119 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс 642,164,490 төгрөгийн 35 ажил, гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн "6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ: 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ": 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- 1.Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын захирал Х.Энхжаргалд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Т.ХОРОЛСҮРЭН

0010801107



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 09 дугаар сарын 15

№ 78/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/16/НА-СТА-УТҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Базаар интернэйшнл ХХК-тай байгуулсан түрээсийн гэрээний төлбөрийн 40 хувь болох 1,200,000.00 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2020 оны 50 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ын 3.6 түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 40 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Түрээсийн гэрээний төлбөрөөс төсөвт төвлөрүүлээгүй 1,200,000.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын захирал Х.Энхжаргалд даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Т.ХОРОЛСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 43/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/16/НД-СТА-УТҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бусдаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний 46,499,500.00 төгрөгийн 16 гэрээт ажлын хөлснөөс 4,649,950.00 төгрөгийн ХХОАТ суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 "үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлснөөс суутгах ХХОАТ болох 4,649,950.00 төгрөгийг нөхөн суутгаж, Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн Төрийн банкны 1200129240870 тоот төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн ТӨҮГ-ын захирал Х.Энхжаргалд даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БАЯН ТАШААГИЙН ЭХ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Т.ХОРОЛСҮРЭН



[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.